



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№202 /412/

2022.11.09

Цаг үе, үйл явдал

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ЖАНЖИН ТУГАНДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Гэрэл зургийг Х.УНДАРМАА

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн өнөөдөр Жанжин туганд хүндэтгэл үзүүлээ.

Уг ёслолын ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа тэргүүтэй ЗХЖШ, төрийн цэргийн командлалуудын удирдлага, мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн, тэдний ар гэрийн төлөөлөл оролцлоо.

Энэ үеэр Батлан хамгаалах дэд сайд Б.Баярмагнай хэлсэн үгэндээ Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх НҮБ-ын 76 дугаар чуулганы индрээс Монгол Улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцогч эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог

15 хувьд хүргэх тодорхой бодлого зорилгыг дэвшүүлэн ажиллахаа илэрхийлсэн. Иймд энэ ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүний 11 хувийг эмэгтэй цэргийн алба хаагч ээлж буй онцлоод "Та бүхэн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны талаарх мэдлэгээ дээшлүүлж, үнэн зөв ойлголттой байх нь туйлын чухал бөгөөд элдэв андуу ташаа мэдээлэл нь Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж ирсэн 20 жилийн түүхийг харлуулж, нийгэмд сөрөг сэтгэгдэл төрүүлж болохыг сайтар ухамсарлан ойлгож, үүргээ нэр төртэй гүйцэтгэнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Монгол Улсын төр засаг, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлагаас хүлээлгэсэн нэр хүндтэй, хариуцлагатай үүргийг цэргийн хэргийн мэдлэг, дадлага, ур чадвартаа тулгуурлан амжилттай гүйцэтгэж, цэргийн багийн удирдлагаас гаргасан шийдвэрийг ёсчлон биелүүлж, хүний газар явахдаа бие биедээ анхаарал халамж тавьж, үүргээ сонор сэрэмжтэй гүйцэтгээрэй" хэмээн захилаа.

Мөн энэ үеэр мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэх эмэгтэй цэргийн алба хаагчдаа төлөөлж ахлах ахлагч Б.Батдэмбэрэл үг хэлсэн юм. Тэрбээр, "Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын төлөөлөл, ажил албандаа мэргэшсэн шилдэг эмэгтэй цэргийн алба хаагчидтайгаа мөр зэрэгцэн ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтаа амжилттай дуусгалаа. Миний хувьд Жанжин тугандаа хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагаанд эмэгтэй цэргийн алба хаагчдаа төлөөлөн үг хэлж байгаадаа туйлын их баяртай байна. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 12 дугаар ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүний 11 хувийг эмэгтэй цэргийн алба хаагчаар бүрдүүлж байна. Тийм ч учраас бид бүхэн монгол цэргийн, тэр тусмаа эмэгтэй алба хаагчдынхаа нэр хүндийг өндөрт өргөж, үүргээ нэр төртэй биелүүлэхээ гүнээ ухамсарлаж байна" хэмээсэн юм.

Ө.НАСАНТОГТОХ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
7	-7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,425	3,430
EUR	3,418	3,440
CNY	469	471
RUB	52.65	52.30
JPY	23.70	24.20
KRW	2.47	2.50

ЗУРХАЙ



ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ
УЛААН БАР ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:

Өвчин ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.49-17.23

БАРИЛДЛАГА:

Үхэх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

САНСАР

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олодо.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 638,070,832

Эдгэрсэн

Нийт: 617,932,363

Нас барсан

Нийт: 6,607,055

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 032 ДУГААР АНГИД...



БРИГАДЫН ГЕНЕРАЛ Г.БОЛОР ШИНЭ ДАЙЧИДТАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ

ЗХЖШ-ын Сургалт Бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор хүрэлцэн ирж, ангийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалттай танилцан, 2022 онд хугацаат цэргийн албанд татагдан ирсэн шинэ дайчидтай Зэвсэгт хүчний бүтэц, "Цэргийн алба-Эх орны алба" сэдвээр

яриа хэлэлцүүлэг өрнүүллээ.

Уулзалт шинэ дайчдын цэргийн албаа үлгэр жишээ хаах урам зоригийг бадраасан халуун дулаан уур амьсгалаар дүүрэн болж өндөрлөсөн бөгөөд бригадын генерал Г.Болор дайчдын цаашдын цэргийн сургалт, бэлтгэлд амжилт хүсэн, дахин уулзалт, ярилцлага хийхээ хэллээ.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА



ШИНЭ ДАЙЧИД АНХНЫ БУУДЛАГЫН ДАСГАЛАА БОЛОВСРУУЛЛАА

Энэ оны 2 дугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан шинэ дайчид цэргийн анхан шатны сургалт бэлтгэлдээ амжилттай хамрагдаж байна. Ангийн захирагчийн тушаалаар энэ сарын 7-ны өдөр хугацаат цэргийн алба хаагчид автомат, пулемётын анхны дасгалыг Хужирбулан дахь сургалтын төвд боловсрууллаа.

Энэй үеэр штабын томилгоот бүрэлдэхүүн, сургалтын төвд ажиллаж буй офицер, ахлагч нар буудлагын явцад хяналт тавьж, аюулгүй ажиллагааг онцгой анхаарч ажиллав.

Дайчдын олонх нь онц буудсан бөгөөд үүндээ урамшиж сэтгэгдэл дүүрнээр дараагийн буудлагыг тэсэн ядан хүлээж буйгаа хэлж байсан юм.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 167 ДУГААР АНГИД...



ЦЭРГИЙН ГАЛ ТОГООНЫ ШАВ ТАВИХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА БОЛЛОО

Өмнөговь аймгийн ЗДТГ-аас нийгмийн хариуцлагын хүрээнд Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн цэргийн гал тогоо орон нутгийн 1,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж байгуулахаар боллоо. Цэргийн гал тогооны шав тавих ёслол өнгөрсөн Бямба гарагт болсон юм.



АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Зэвсэгт хүчинд хоёргүй сэтгэлээр зүтгэж эл ангиас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад дайчид настан буурлуудаа билэгт сайн өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүллээ

Ангийн захирагч дэд хурандаа Х.Лхагвадорж ангийн түүхэн замнал, хөгжлийн чиг хандлага, амжилт бүтээл болон удахгүй тохиох 50 жилийн ойн арга хэмжээний тухай болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө ахмадууддаа танилцуулсан юм. Мөн бэлтгэл дэд хурандаа Ш.Энхболд ахмадын зөвлөлөөс хэрэгжүүлсэн ажлуудаа нийт бие бүрэлдэхүүнд тайлагнав. Мөн энэ үеэр төрийн болон салбарын шагналаар хүндэт буурлуудынхаа энгэрийг мялаасан нь баяр дээр баяр нэмсэн үйл явдал боллоо.



АЛБА, САЛБАР СУРТАЛЧЛАХ АЯНЫ ТУГИЙГ ГАРДУУЛЛАА

Ажиллагааны удирдлагын тасгийн дарга хошууч Н.Гуррагчаад, захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Ж.Үүрцайх алба сурталчлах шилжин явах тугийг гардуулан өглөө. Ангийн бие бүрэлдэхүүний гар нийлэмжтэй ажиллагааг хангах, хамтач нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир, спорт, соёл хүмүүжлийн ажлыг шинэлэг хэлбэрээр тогтмол зохион байгуулах зорилгоор Зэвсэгт хүчний 167 дугаар анги нь "Алба, салбар сурталчлах" аяныг эхлүүлж байна.

"ЯВУУЛЫН НОМЫН САН", "НОМТОЙ НӨХӨРЛӨӨ" АЯНЫГ ӨРНҮҮЛЭВ



Өмнөговь аймгийн төв номын сантай хамтран "Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын дунд "Явуулын номын сан", "Номтой нөхөрлөө" аяныг амжилттай өрнүүллээ.

Уг арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан асуулт,



хариултын "АХА" тэмцээний тэргүүн байрт байлдагч О.Баянсан, дэд байрт Ц.Онги, "Дараагийн хуудас" зохион бичлэгийн уралдааны тэргүүн байрт байлдагч Г.Баттулга, дэд байрт Э.Тамир нар тус тус шалгарч бусад нөхдөө манлайлав.

Дэслэгч Б.БАТЗАЯА



СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №20

ГИЙГҮҮЛЭГЧ ҮСГИЙН БҮТЭЦ ЗУРЛАГА

Өнөөгийн монгол бичгийн цагаан толгой 7 богино эгшиг, эх хэлний үг, мөн харь гаралтай үг тэмдэглэх 22 гийгүүлэгчээс бүрдэнэ.

Монгол бичгийн гийгүүлэгч үсгийг үзэхийн тулд "ДЭВСГЭР ҮСЭГ" гэсэн ойлголтыг зайлшгүй мэдэх шаардлагатай болдог. Монгол бичгээр үе юм уу үгийн төгсгөлд ардаа эгшигийг орж болдог гийгүүлэгчийг ДЭВСГЭР ҮСЭГ гэнэ. Юуны тулд дэвсгэр үсэг гэж нэрлэсэн бэ гэвэл: Үе, үгийн адагт, доор нь "дэвсэж" ордог учраас,



Тухайн үгийг цааш хувилгахдаа ямар эхлэлтэй дагавар, нөхцөлийг залгах юм уу дагуулж бичихийн суурь үндэс /дэвсгэр/ болдог учраас гэж ойлгож болно. Үгийн эхэнд орвол дэвсгэр үсэг ч ардаа эгшигтэй байна.

Монгол бичигт, тодорхой хэдэн дэвсгэр үсэг буй бөгөөд тэдгээрийг "Хатуу дэвсгэр", "Зөөлөн дэвсгэр" гэж ангилдаг.

На, Ма, Ла, НГ эдгээрийг зөөлөн дэвсгэр гэнэ. "МАНЛАНГ" хэмээх зохиомол үгээр тогтоодог. Ба, Га, Ра, Са, Да эдгээрийг хатуу дэвсгэр гэнэ. БАГАРСАД" хэмээх зохиомол үгээр тогтоодог.